



ӨЛГИЙ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Д.Назгүл
Утас:99427301
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.gov.mn

2018 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 05-ны өдрийн №01/99 тоот албан бичгээр 3 дугаар сарын 15-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 16-наас 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 26 -нд Өлгий сумын Засаг даргад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Хүний нөөц, газар, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцаа бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Өлгий сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Өлгий сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 25-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад **төсөвт байгууллагууд нь** санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэн тайлан гаргахад Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 17375,6 сая төгрөгийн санхүүжилт, 90,9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан ба төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,8 сая төгрөгийн, НД-ын сангаас 42,3 сая төгрөгийн буюу тусгай шилжүүлгийн байгууллагууд бүгд дүнгээр 17510,7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 432,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 635,6 сая төгрөгийн, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 42,7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 14,6 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 228,0 сая төгрөгийн буюу нийтдээ 1353,6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна.

6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Өлгий сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас оруулах орлогын төлөвлөгөө байхгүй ба Сум хөгжүүлэх сангийн орлогоос 1,7 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 24,6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

6.1.4 Орон нутгийн татварын орлого

Өлгий сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 315,4 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 73,7 хувийг ХАОАТатвараас, 3,7 хувийг өмчийн татвараас, 4,6 хувийг бусад татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	315,4	635,6	320,2	201,5%
Татварын орлого	258,6	546,5	287,9	211,3%

ХАОАТатвар	232,5	527,2	294,7	226,7%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	6,6		-6,6	0%
Өмчийн татвар	11,6	9,3	-2,2	80,2%
Бусад татвар	14,5	9,9	-4,6	68,3%
Татварын бус орлого		68,9	68,9	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	56,8	20,1	-36,7	35,4%

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 315,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 320,2 сая төгрөгөөр буюу 101,5 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 85,9 хувийг татварын орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 294,7 сая төгрөгөөр буюу 111,3 хувиар, татварын бус орлого 68,9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Бусад татвар 4,6 сая төгрөгөөр буюу 31,9 хувиар, өмчийн татвар 2,2 сая төгрөгөөр буюу 19,4 хувиар тасарчээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 6,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 635,6 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 320,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

6.1.5 Бусад орлого

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангаас 228,0 сая төгрөгийн санхүүжилт авч, Хала өркени ОНӨААН-ийн үйл ажиллагааны орлогоос 10,9 сая төгрөгийн орлого оруулсан байна.

6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 18345,6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Санхүүжлэх эх үүсвэрийн хувьд 17375,6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 740,2 сая

төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,7 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 17375,6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 740,2 сая төгрөгийн, ОНХСангаас 228,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 24,6 сая төгрөг оруулж нийтдээ 18368,4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэл 18347,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч батлагдсан төсвөөс 1,4 сая төгрөгөөр илүү зарлага гаргасан байна. Энэ төсөвт байгууллагуудын оны эхний мөнгөн хөрөнгийн зарцуулалт 1,4 сая төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.
/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /мөнгөн дүнгээр/	Зөрүү /Хувиар/
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	18345,6	18347,0	8,5	100,05%
1.1	Урсгал зардал	18345,6	18354,1	8,5	100,05%
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	18345,6	18375,5	29,9	100,2%
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	17375,6	17375,5		100%
2.2	Орон нутгийн төсвөөс	968,3	968,3	-	100%
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	228,0	228,0		100%
2.4	Үйл ажиллагааны орлогоос	1,7	24,6	22,9	144,7%

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал: /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумын ИТХурал	63,8	63,8		
Сумын ЗДТГазар	571,8	572,4	-0,6	
Бүрэн дунд сургуулиуд	9607,3	9607,6	-0,3	
Бага сургуулиуд	1171,8	1171,8		
Хүүхдийн цэцэрлэгүүд	4589,0	4589,6	-0,6	
Хувийн сургуулиуд	1264,9	1264,9		
Хувийн цэцэрлэгүүд	170,6	170,6		
Хүн эмнэлэг	572,0	572,0		
Хот тохижуулах алба	210,7	210,7		
ОНХСан	121,8	121,8		
СХСан	1,7	1,7		
Бүгд	18345,6	18354,1	-1,4	

Байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18345,6	18347,0	1,4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11610,6	11610,5	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1269,5	1269,4	-0,1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1310,9	1309,2	-1,7
Хангамж, бараа материалын зардал	148,8	148,5	-0,3
Нормативт зардал	963,1	962,8	-0,3
Эд хогшил, урсгал засварын зардал	41,1	41,8	0,7
Томилолт, зочны зардал	12,4	12,3	-0,1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,0	48,1	2,1
Бараа үйлчилгээний бусад зардал	156,5	157,2	0,7
Бусад урсгал шилжүүлэг	2664,7	2665,3	0,6
Хөрөнгийн зардал	121,9	121,9	-1,0

6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ **105,5** сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд **105,5** сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

6.2.3 Сангуудын зарцуулалт

ОНХСангаас тайлант онд 228,0 сая төгрөгийн санхүүжилт авсаны 121,9 сая төгрөгийг Өлгий сумын ИТХурлаас батлагдсан ОНХСангийн төсөл арга хэмжээнд зарцуулсан ба үйл ажиллагааны орлогоос 7,1 сая төгрөг оруулж, “Хала-Өркени” ОНӨОҮГ-т шилжүүлсэн. 5,5 сая төгрөгийг сумын ЗДТГ-т мал эмнэлгийн үйлчилгээний зардалд, 100,7 сая төгрөгийн Хот тохижуулах албаны санхүүжилтэнд олгосон байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,07 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 24,6 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд зээл олгоогүй, бараа үйлчилгээний зардалд 1,7 сая төгрөг зарцуулж оны эцэст 22,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. СХСан нь жилийн эцэст 987,2 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
------------	-------------------	----------------	-----------------	---------------

31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,5	396,4	387,9
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0,03	0,03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,5	396,4	387,9
3121	Төгрөг			
31211	Төрийн сангийн харилцах	6,9	357,8	350,9
31213	Арилжааны банк дахь харилцах	1,64	0,05	-1,59
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		38,5	38,5

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 396,4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,05 сая төгрөг нь арилжааны банкинд дахь, 38,5 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн харилцах дахь, 357,8 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 334,8 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 22,9 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл байна.

6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	1064,7	1068,9	4,2
333	Татаас, санхүүжилтийн авлага	26,6	26,6	
333	Ажиллагсадтай хоблоотой авлага	4,9	9,7	4,8
333	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,9	17,0	13,1
335	Бусад авлага	24,1	28,3	4,2
336	Хувь хүмүүст олгосон зээл	1005,2	987,2	-18,0

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 4,2 сая төгрөгөөр өссөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, ОНХСангийн татаас санхүүжилтийн авлагыг барагдуулаагүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	505,8	588,8	83,0
351	Түүхий эд материал	22,5	24,5	2,0
354	Хангамжийн материал	479,4	560,1	80,7

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 83,0 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 95,1 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 57,2 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24857,9	24936,6	78,7
391	Газар			
392	Биет хөрөнгө	24852,9	24932,8	79,9
	Хуримтлагдсан элэгдэл	-9445,4	-10667,1	1221,7
393	Биет бус хөрөнгө	19,4	19,4	-
	Хуримтлагдсан элэгдэл	-14,4	-15,6	1,2

Үндсэн хөрөнгө оны эхнээс 78,7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 28,5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 1662,7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Тайлант онд 324,6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 1501,9 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 290,3 сая төгрөгний элэгдэлийг данснаас хасалт хийж, зөрүүг хөрөнгө акталсаны гарзаар бүртгэсэн байна.

6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	248,6	382,2	133,6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	228,6	362,2	133,6
413	Өглөг	228,6	362,2	133,6
4136	Бусад өглөг			
41361	Байгууллагад төлөх өглөг	34,4	111,1	76,7
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,5	40,7	21,2
41330	Татаас санхүүжилтийн өглөг	135,6	117,1	-18,5
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	39,0	93,3	54,3
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,0	20,0	

Оны эцэст ИТХ 0,1 сая төгрөгийн, ЗДТГ 2,0 сая төгрөгийн, 1-р БДС 57,9 сая төгрөгийн, 2-р БДСургууль 38,9 сая төгрөгийн, 3-р БДСургууль 1,9 сая төгрөгийн, 4-р БДСургууль 40,9 сая төгрөгийн, 5-р БДСургууль 5,8 сая төгрөгийн, 6-р ахлах сургууль 6,1 сая төгрөгийн, 1-р Бага сургууль 1,6 сая төгрөгийн, Хотгор бага сургууль 0,2 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгүүд 29,6 сая төгрөгийн, ОНХСан 115,6 сая төгрөгийн, "Хала-Өркени" ОНӨОҮГ 79,4 сая төгрөгийн, Хот тохижуулах алба 0,7 сая төгрөгийн, Төрийн сан 1,5 сая төгрөгийн буюу нийтдээ 382,2 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 26608,6 сая төгрөг буюу ЗГОКапитал 11103,3 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 4024,1 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 11481,2 сая төгрөг байна. Тайлант онд 413,9 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж,

хуримтлагдсан үр дүн оны эхнээс 845,4 сая төгрөгөөр өссөн байна. Зөрүү нь “Хала-Өркени” ОНӨААН-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн бичилт байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2017 онд хийсэн нийцлийн аудитаар сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн 44.1.3, 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.3.5, 6.3.8, 6.3.9, 6.4.4, 6.4.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн ба зөрчлийг арилгаж 2017.12.26 №1/722 тоотойр биелэлтийг ирүүлсэн байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Tsengel sumiin ТТЗ файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Найм. Аудитын дүнгийн талаар

8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 39 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус дараах алдаа, зөрчил илэрлээ.

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тэмдэглэл тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” батлах тухай зааварын дагуу бэлтгэж ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тусгаж, зөвлөмж болгов.

2. Сум хөгжүүлэх сан нь жилийн эцсийн байдлаар 987,2 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд авлагын үлдэгдэлд тайлант хугацааны хүүг тооцож, орлогоор бүртгэж аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тусгаж, дараа оны аудитаар алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөв.

3. Сум хөгжүүлэх сан нь тайлант оны эхэнд 1005,2 сая төгрөгийн зээлийн авлагатай боловч тайлант онд төлөгдөх хэмжээгээр төсөв батлагдаагүй буюу төсвийг 1,7 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тусгаж, Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг үндэслэлтэй хийж, батлуулах талаар зөвлөв.

8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сум хөгжүүлэх сангийн зөвхөн төрийн сангийн дансны хуулга болон санхүүгийн тайланг ирүүлсэн ба Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн тооцоололтой холбоотой санхүүгийн материалаа ирүүлээгүй.

8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт олгсон санхүүжилтийн тооцоо, Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын тооцоог гүйцэд шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн аудитаар нарийвлан шалгаж дүгнэлт гаргах шаардлагатай.

8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Тайлант онд Өлгий сумын 24 төсөвт байгууллага, 1 ОНӨОУГазрын тайлант бие даасан дүгнэлт гаргасан.

Өлгий сумын Өрхийн эмнэлгэ, Хүүхдийн 2, 4, 11, 12 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, сумын ЗДТГ, ИТХурал, Хотгор бага сургууль, Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБ-ын 1-р БДСургууль	59,0	1		1		
ЕБ-ын 2-р БДСургууль		1	1			
ЕБ-ын 3-р БДСургууль	1,3	1	1			
ЕБ-ын 4-р БДСургууль	40,9	1		1		
ЕБ-ын 5-р БДСургууль		1	1			
ЕБ-ын 6-р БДСургууль	17,1	1	1			
1-р бага сургууль		1	1			
"Эрдэм" бага сургууль	17,9	1	1			
1-р хүүхдийн цэцэрлэг		1	1			
3-р хүүхдийн цэцэрлэг		1	1			
5-р хүүхдийн цэцэрлэг	2,4	1	1			
6-р хүүхдийн цэцэрлэг		1	1			

7-р хүүхдийн цэцэрлэг	1,2	1	1		
8-р хүүхдийн цэцэрлэг		1	1		
9-р хүүхдийн цэцэрлэг		1	1		
10-р хүүхдийн цэцэрлэг	0,3	1	1		
"Эрдэм" хүүхдийн цэцэрлэг	2,3	1	1		
13-р хүүхдийн цэцэрлэг	2,0	1	1		
15-р хүүхдийн цэцэрлэг		1	1		
16-р хүүхдийн цэцэрлэг		1	1		
17-р хүүхдийн цэцэрлэг	0,7	1	1		
18-р хүүхдийн цэцэрлэг	16,3	1	1		
Хотгор цэцэрлэг		1	1		
Хотгор Эрүүл мэндийн төв		1	1		
"Хала-Өркени" ОНӨОҮГ		1		1	
Өлгий сумын ТТЗ-ийн СНТ		1	1		
Дүн	161,4	26	23	3	

8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:2018.04.06

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:2018.04.06

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ
Огноо:2018.04.06